



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/170

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 251 дүгээр зүйлийн 251.3 дахь хэсэг, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэх, Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 536 дугаар тушаалын үндэслэх хэсэгт “Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 251 дүгээр зүйлийн 251.3, Улсын гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь” гэж заасныг “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 251 дүгээр зүйлийн 251.3 дахь хэсэг, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь” болгож өөрчилсүгэй.

2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Ё.Бат-Эрдэнэ/-д Төрийн захиргааны удирдлагын газар /Ц.Гэндэнцэвээн/, Зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газар /Б.Онон/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АСРАЛТ

0001291